

## **ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

### **Нэг. Хууль, тогтоолын төсөл боловсруулах үндэслэл, шаардлага**

#### *1.1 Хууль зүйн үндэслэл, шаардлага*

Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин зургадугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, баталгааг хуулиар тогтооно.” гэж заасан.

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 7 дахь хэсэгт “...Төрийн санхүү, төсвийн хяналтыг хараат бусаар хэрэгжүүлэх байгууллагын бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно;”, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Алсын хараа 2050” Монгол Улсын Урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа”-ны “Зорилт 4.1.2.Төсвийн хөрөнгийг эдийн засаг, нийгмийн хөгжилд чиглүүлсэн, үр ашигтай, хариуцлагатай төсөв, санхүүгийн тогтолцоотой болсон байна.” гэж тус тус заасан.

#### *1.2 Практик хэрэгцээ шаардлага*

Монгол Улсын төсвийн тогтвортой байдлыг хангуулах, холбогдох шинжилгээ хийх, дүгнэлт, зөвлөмж гаргах үүрэг бүхий орон тооны 7 гишүүний бүрэлдэхүүнтэй зөвлөл Улсын Их Хурлаас томилогдсон. Тус Зөвлөлийн дарга, гишүүн нь Төрийн өндөр албан тушаалтны зэрэг зиндаа, түүнтэй адилтгах төрийн албан тушаалтны зэрэглэлийн захиргааны адилтгах албан тушаалд хамаарагдана. Иймд Зөвлөлийн дарга, гишүүний эрх зүйн байдлыг Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нарийвчлан хуульчилж өгөх бодит хэрэгцээ шаардлага бий болсон. Ингэснээр Зөвлөл үйл ажиллагаагаа бие даасан, хараат бус, ил тод, хуульд нийцүүлэн хэрэгжүүлэх боломж бүрдэнэ.

Иймд Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон түүнтэй уялдуулан дагалдах хууль, Улсын Их Хурлын тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл боловсруулах хэрэгцээ шаардлага үүссэн.

**Хоёр.Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ**

Хуулийн төслийн зорилго нь Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга, гишүүдийн эрх зүйн байдлыг нарийвчлан тогтоох, үйл ажиллагааны баталгаа болон баталсан хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангахад чиглэгдэнэ. Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 22 дүгээр зүйлийн 22.1.2 дахь заалтын дагуу өөрчлөлт оруулах хуулийн төслийн хэлбэрээр боловсруулна.

Мөн Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан бусад хуультай нийцүүлэх үүднээс дагалдах хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулна. Дагалдах хуулиудад Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Монгол Улсын Их Хурлын 2019 оны 2 дугаар сарын 01-ний өдрийн 19 дүгээр тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай, 2024 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 03 дугаар тогтоолын хавсралтыг өөрчлөн батлах тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл зэрэг байна.

**Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх арга хэмжээний санал**

### *3.1. Эдийн засгийн үр дагаврын хүрээнд*

Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл батлагдсанаар Улсын төсөвт нэмэлт зардал шаардлагагүй болно. Иймд Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4 дэх заалтад заасан хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан гарах зардлын тооцоог хийх шаардлагагүй.

### *3.2. Нийгмийн үр дагаврын хүрээнд*

Төсвийн ил тод байдлыг хангах, хөндлөнгийн хяналтыг сайжруулах, төрийн аудитын хяналтыг бэхжүүлэх, төсвийн хяналтыг сайжруулах, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нийцүүлж төсвөө боловсруулдаг болох, төсөв санхүүгийн үр ашиг, гадаад зээл тусламжийн үр өгөөж дээшилж, төсвийн үргүй зардал багасах зэрэг ач холбогдолтой юм.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тусгасан Төсвийн тогтвортой байдлын зөвлөл нь төрийн захиргааны албаны ангилал бүхий Улсын Их Хурлын дэргэдэх бүтцийн байгууллага тул Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2, 12.2.21 дэх заалтад тус тус заасны дагуу хууль тогтоомжийн хэрэгцээ шаардлагыг урьдчилан тандан судлах, үр нөлөөг үнэлэх судалгааг хийх шаардлагагүй болно.

### *3.3. Хууль зүйн үр дагаврын хүрээнд*

Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин зургадугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, баталгааг хуулиар тогтооно” гэж заасны дагуу Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга, гишүүдийн эрх зүйн байдлыг оновчтой, нарийвчлан тогтоох, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Алсын хараа 2050” Монгол Улсын Урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа”-ны “Зорилт 4.1. 2.Төсвийн хөрөнгийг эдийн засаг, нийгмийн хөгжилд чиглүүлсэн, үр ашигтай, хариуцлагатай төсөв, санхүүгийн тогтолцоотой болсон байна” зэрэг бодлогын баримт бичигт тусгагдсан эрх зүйн орчин бүрдэх ач холбогдолтой юм.

**Дөрөв.Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох хуулийн төслийн талаар**

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжид нийцсэн. Уг хуулийн төсөлтэй холбогдуулан Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Монгол Улсын Их Хурлын 2019 оны 2 дугаар сарын 01-ний өдрийн 19 дүгээр тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай, 2024 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 03 дугаар тогтоолын хавсралтыг өөрчлөн батлах тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл зэрэг байна.

## **ХУУЛЬ САНААЧЛАГЧ**